



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/606

Алтай хот

**Комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр Цогт сумын "Ээж хайрхан" ууланд аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газарт ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:	М. Мандаххүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ш. Мөнхцэцэг	(Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)
	Г. Болдбаатар	(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Р.Пүрэвдорж	(Орон нутаг өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	М.Мөнхцэцэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Л.Насанбуян	(Цогт сумын Засаг дарга)

2.

Ч.Хишигбаатар (“Алаг царам” ХХК захирал)


(гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:Б.Гансүх

(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Цогт сумын “Ээж хайрхан” ууланд аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газарт ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан ажлын даалгавар, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт, холбогдох баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэн, хууль журмын дагуу хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгахыг Цогт сумын Засаг дарга (Л.Насанбуян)-д, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ